

*ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ЭНХБАТЫН “ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ  
МАЛ АЖ АХУЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ОЛОН ТАЛТ ТҮНШҮҮДИЙН 8 ДУГААР УУЛЗАЛТЫН  
ДҮГНЭЛТ ҮГ*

Эрхэм зочид, төлөөлөгчид та бүхнийхээ өглөөний амар амгаланг айлтган мэндчилэе

- Та бид 5 өдрийн турш мал аж ахуйн салбарыг байгаль цаг уурын онцлогт тохируулан тогтвортой хөгжүүлж хүн амыг эрүүл чанартай хүнсээр хүртээмжтэй хангах үйлсэд үнэтэй хувь оруулахаар оюун бодлоо хуралдуулан ажиллаа.
- Монгол Улсын Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ удаагийн хуралд ихээхэн анхаарал хандуулж Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, төрийн захиргааны байгууллага, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага болон эгэл жирийн малчдын төлөөллөөс бүрдсэн нийт 200 гаруй дотоодын төлөөлөгч амжилттай оролцлоо.
- Та бүхэн энэхүү уулзалтад идэвхтэй, ажил хэрэгч байж харилцан ашигтай хамтын ажиллагааны суурийг оролцогч байгууллага, хувь төлөөлөгчийн түвшинд амжилттай тогтоож чадсан хэмээн найдаж байна.
- Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөр нь 2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг оролцогчдоор хэлэлцүүлэн тэдний саналыг тусган, хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг нийгмийн эрэлт хэрэгцээ, байгаль, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдалтай уялдуулж байгаагаараа онцлог байлаа.
- Олон талт түншүүдийн 8 дугаар уулзалтыг хамтран зохион байгуулсан Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар, Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн хамт олонд гүнээ талархсанаа илэрхийлэе.
- Энэхүү олон талт түншүүдийн 8 дугаар хурал нь Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутагт унаган төрхөө хадгалан

- үлдсэн байгальд малчны хотны дэргэд зохион байгуулсан нь онцлогтой боллоо.
- Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг батлан гаргалаа.
  - Энэхүү уулзалтаас Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбар, Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөр, түүний түнш, хандивлагч байгууллагуудын хамтын ажиллагаанд шинэ талбар нээгдлээ хэмээн харж байна.
  - Энэхүү төлөвлөгөө нь бидний хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэн дэлхийн дахинд тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудалд томоохон хувь нэмэр оруулах болно.

Ингээд бид тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хамтын ажиллагааны анхны баримт бичиг болгон ноён Фритз танд өргөн барьж байна. Хүлээн авна уу